

ХҮНИЙ НӨӨЦ

Шинэчлэгдсэн бүтцээр Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газар, Үнэлгээ, мониторингийн газар, Хяналт шалгалтын газар, Хууль эрх зүйн газар, Мэдээлэл, технологи, системийн шинжилгээний газар, Тамгын газар, Дотоод хяналт, аудитын газар гэсэн үндсэн 7 газар, 8 хэлтэст /2025 оны 4 дүээр сарын байдлаар/ 127 албан хаагч ажиллаж байна.

Албан хаагчдын 46 хувь нь эрэгтэй, 54 хувь нь эмэгтэй байгаа бол насны хувьд нийт албан хаагчдын 70 хувь нь 36-55 насныхан эзэлж байна. /График-1/

Албан хаагчдыг төрд ажилласан жилээр нь авч үзвэл 24 хувь нь 3 хүртэл жил, 20 хувь нь 3-10 хүртэлх жил ажиллаж байгаа бол албан хаагчдын **56** хувь нь 10-аас дээш жил ажилласан туршлагатай байна. /График-2/ Зарим газар, нэгжийн чиг үүрэг, төсөл, арга хэмжээний онцлогтой холбоотой байгууллагын дүрэм, журмын дагуу ажиллуулж буй гэрээт зөвлөх, судлаач, шинжээч нар 9 хувийг эзэлж байна.

Одоогийн албан хаагчдын 8 хувь нь байгууллага анх үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш буюу 2 жил гаран хугацаанд ажиллаж байгаа бол 12 сар хүртэлх хугацаанд ажиллаж буй албан хаагчид нийт албан хаагчдын 76 хувийг эзэлж байна.

График 1. Албан хаагчдын хүйс, насны ангилал




График 2. Албан хаагчдын төрд ажилласан хугацаа





График 3. Албан хаагчдын энэ байгууллагад ажилласан хугацаа, боловсролын зэрэг



Боловсролын зэргийн хувьд 2 хувь нь доктор, 48 хувь нь магистр зэрэгтэй байгаа бол 48 хувь нь бакалаврын зэрэгтэй байна.

Үндсэн мэргэжлийн ангиллын хувьд 30 хувь нь эрх зүйч, харин бизнесийн удирдлага, менежмент, төрийн захиргаа, улс төр, олон улсын харилцааны чиглэлийн мэргэжилтэй албан хаагчид 21 хувь, эдийн засаг, математик, статистик чиглэлийн мэргэжил эзэмшсэн албан хаагчид 10 хувь, багш, орчуулагч, нийгэм, социологи, анагаах ухааны чиглэлээр мэргэжил эзэмшсэн албан хаагчид 15 хувийг тус тус эзэлж байна. /График-4/

График 4. Албан хаагчдын үндсэн мэргэжлийн чиглэл

